

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2026/145/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

Аудитор: Х.Еркегүл  
Утас: 99040705  
Цахим хаяг: [erkegulkh@audit.gov.mn](mailto:erkegulkh@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

---

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 427  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ш.ЖАВХЛАН ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн ИТХ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Хуралдааны хоол, цайны завсарлагааны зардалд хүний тоо, хуралдааны ирцийн бүртгэлийг үндэслэлгүй 30.6 сая төгрөгийг олгосон. Тухайлбал иргэдийн төлөөлөгчдийн хуралдаан, зөвлөл, бүлэг, хороодын хуралд нийт 548 хүн оролцсон боловч хоолны зардлыг 978 хүн, цайны завсарлагаанд 1649 хүнээр тооцож төсвийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулан нягтлан бодох бүртгэл хөтөлж, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан;

Ашиглалтын гэрээгээр ашиглаж буй аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцны засварын зардалд 15.0 сая төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой тусгаагүй, зураг төсөвгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгасан;

Цалингийн зардлаас түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй 4 албан хаагчид цалингийн нэмэгдэлд 29.0 сая төгрөг, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид 1.7 сая төгрөгийн нэмэгдэл, томилолтоор ажилласан албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож 2.8 сая төгрөг, ээлжийн амралтын хугацаанд 1.0 сая төгрөг, албан тушаал өөрчилсөн тушаал шийдвэрийн хугацааг үндэслэлгүй 0.6 сая төгрөгийн цалинг тус тус илүү олгосон зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,663.8 сая төгрөгийн санхүүжилт авч 93 хувь буюу 1,552.8 сая төгрөгийг зарцуулж 11.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 54.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 53.9 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн зарцуулагдаагүй үлдэгдэл 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 97.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 16.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, төсвийн зарцуулалттай холбоотой 1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, төсвийн үр ашиг, арвилан хэмнэлттэй холбоотой 79.1 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 35 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 90.3 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,751,730.00</b>	<b>18,223,868.70</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	110,700.00	1,820,700.00
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	110,700.00	1,820,700.00
3121	<b>Төгрөг</b>	110,700.00	1,820,700.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	110,700.00	1,820,700.00
33	<b>АВЛАГА</b>	-	<b>991,308.70</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	131,308.70
335	<b>Бусад авлага</b>	-	<b>860,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	860,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>31,641,030.00</b>	<b>15,411,860.00</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>31,641,030.00</b>	<b>15,411,860.00</b>
35410	Бичиг хэргийн материал	614,550.00	296,500.00
35420	Аж ахуйн материал	28,364,480.00	3,257,360.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,662,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	11,858,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>83,146,750.99</b>	<b>98,215,145.06</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	83,146,750.99	98,215,145.06
392	<b>Биет хөрөнгө</b>	83,146,750.99	98,215,145.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,790,308.00	176,790,308.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139,899,728.09)	(148,757,789.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,385,808.40	87,726,993.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,507,091.86)	(40,303,317.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,351,860.50	30,388,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,974,405.96)	(11,629,748.36)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,000,000.00	4,000,000.00
39301	Програм хангамж	320,000.00	320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(320,000.00)	(320,000.00)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>114,898,480.99</b>	<b>116,439,013.76</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>46,746,308.70</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	46,746,308.70
413	<b>Өглөг</b>	-	46,746,308.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	131,308.70
4136	<b>Бусад өглөг</b>	-	46,615,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	36,305,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	10,310,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>114,898,480.99</b>	<b>69,692,705.06</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	114,898,480.99	69,692,705.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	102,550,728.00	102,550,728.00
51101	Өмч: - төрийн	102,550,728.00	102,550,728.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>8,780,196.99</b>	<b>(36,425,578.94)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	8,780,196.99	8,780,196.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(45,205,775.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,567,556.00	3,567,556.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>114,898,480.99</b>	<b>116,439,013.76</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,372,651,800.00</b>	<b>1,730,089,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,388,000.00</b>	<b>11,500,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,388,000.00</b>	<b>11,500,000.00</b>
<b>120004</b>	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>3,388,000.00</b>	<b>11,500,000.00</b>
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,000,000.00
<b>1200045</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,388,000.00	5,500,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,369,263,800.00</b>	<b>1,718,589,200.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>324,000,000.00</b>	<b>54,755,500.00</b>
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	321,000,000.00	51,070,000.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	3,685,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,045,263,800.00</b>	<b>1,663,833,700.00</b>
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,045,263,800.00	1,663,833,700.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,370,972,863.18</b>	<b>1,751,228,105.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,370,972,863.18</b>	<b>1,751,228,105.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,177,143,868.06</b>	<b>1,402,925,734.40</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>458,999,694.10</b>	<b>518,293,557.27</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	252,743,479.01	298,079,186.79
<b>210102</b>	Нэмэгдэл	139,582,357.73	136,179,834.48
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	35,714,617.27	49,644,000.00
<b>210104</b>	Урамшуулал	30,959,240.09	34,390,536.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,424,505.44</b>	<b>65,322,870.00</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	39,955,543.45	44,433,015.30
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	4,632,090.00	5,227,413.69
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	2,306,145.51	2,610,406.82
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	2,306,145.51	2,610,406.82
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	9,224,580.97	10,441,627.37
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,507,230.00</b>	<b>56,558,430.00</b>
<b>210401</b>	Бичиг хэрэг	815,400.00	7,356,950.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	25,510,000.00	45,000,000.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,181,830.00	4,201,480.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,794,100.00</b>	<b>100,847,120.00</b>
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	1,324,500.00	350,000.00
<b>210603</b>	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,212,000.00	-
<b>210604</b>	Урсгал засвар	19,257,600.00	100,497,120.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>30,676,000.00</b>	<b>35,770,000.00</b>
<b>210702</b>	Дотоод албан томилолт	30,676,000.00	35,770,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>182,463,186.34</b>	<b>458,448,283.20</b>
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,343,868.34	455,606,386.20
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	2,943,000.00	2,500,000.00
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	118,318.00	266,397.00
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	75,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>393,279,152.18</b>	<b>167,685,473.93</b>
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	321,000,000.00	46,580,000.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,364,065.00	91,300,758.00
<b>210903</b>	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,915,087.18	29,804,715.93

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,828,995.12</b>	<b>348,302,371.53</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	117,200,000.00	175,000,000.00
<b>213101</b>	Засгийн газрын дотоод шилжүүлэг	117,200,000.00	175,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,179,012.00</b>	<b>62,248,071.00</b>
<b>213202</b>	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,590,456.00	-
<b>213205</b>	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	21,213,360.00
<b>213208</b>	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,101,156.00	8,623,500.00
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,487,400.00	32,411,211.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,449,983.12</b>	<b>111,054,300.53</b>
<b>213403</b>	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,449,983.12	111,054,300.53
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,678,936.82</b>	<b>(21,138,905.93)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>24,066,870.00</b>
<b>225005</b>	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	24,066,870.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	<b>(24,066,870.00)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,678,936.82</b>	<b>(45,205,775.93)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,369,371,900.00</u></b>	<b><u>1,724,589,200.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>6,000,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>6,000,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>6,000,000.00</b>
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,000,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,369,371,900.00</b>	<b>1,718,589,200.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>324,108,100.00</b>	<b>54,755,500.00</b>
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	321,000,000.00	51,070,000.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,108,100.00	3,685,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,045,263,800.00</b>	<b>1,663,833,700.00</b>
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,045,263,800.00	1,663,833,700.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,353,862,000.00</u></b>	<b><u>1,683,506,090.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,353,862,000.00</b>	<b>1,683,506,090.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,158,613,004.88</b>	<b>1,334,331,119.47</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>458,999,694.10</b>	<b>518,293,557.27</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	251,368,128.67	298,079,186.79
<b>210102</b>	Нэмэгдэл	140,957,708.07	136,179,834.48
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	35,714,617.27	49,644,000.00
<b>210104</b>	Урамшуулал	30,959,240.09	34,390,536.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,841,729.44</b>	<b>65,322,870.00</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	39,372,767.45	44,433,015.30
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	4,632,090.00	5,227,413.69
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	2,306,145.51	2,610,406.82
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	2,306,145.51	2,610,406.82
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	9,224,580.97	10,441,627.37
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,663,330.00</b>	<b>54,066,130.00</b>
<b>210401</b>	Бичиг хэрэг	1,471,500.00	4,864,650.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	25,010,000.00	45,000,000.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,181,830.00	4,201,480.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>981,000.00</b>	-
<b>210503</b>	Нормын хувцас, зөөлөн эдлэл	981,000.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,200,100.00</b>	<b>96,299,920.00</b>
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	1,324,500.00	1,918,760.00
<b>210603</b>	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,618,000.00	-
<b>210604</b>	Урсгал засвар	19,257,600.00	94,381,160.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,256,000.00</b>	<b>35,770,000.00</b>
<b>210702</b>	Дотоод албан томиллолт	29,256,000.00	35,770,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>182,963,186.34</b>	<b>425,026,274.20</b>
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,843,868.34	422,184,377.20
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	2,943,000.00	2,500,000.00
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	118,318.00	266,397.00
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	75,500.00

2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>374,707,965.00</b>	<b>139,552,368.00</b>
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	321,000,000.00	46,580,000.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,707,965.00	92,972,368.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>195,248,995.12</b>	<b>349,174,970.53</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	117,000,000.00	175,000,000.00
<b>213101</b>	Засгийн газрын дотоод шилжүүлэг	117,000,000.00	175,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>70,799,012.00</b>	<b>62,260,670.00</b>
<b>213205</b>	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	21,213,360.00
<b>213208</b>	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,691,612.00	8,623,500.00
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,107,400.00	32,423,810.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,449,983.12	111,054,300.53
<b>213403</b>	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,449,983.12	111,054,300.53
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>860,000.00</b>
<b>213503</b>	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	860,000.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,509,900.00</u></b>	<b><u>41,083,110.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,509,900.00</b>	<b>39,373,110.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,509,900.00</b>	<b>39,373,110.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	15,509,900.00	39,373,110.00
<b>223001</b>	Бусад хөрөнгө	15,509,900.00	39,373,110.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(15,509,900.00)</u></b>	<b><u>(39,373,110.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
24	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	-	-
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	1,710,000.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>110,700.00</b>	<b>110,700.00</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>110,700.00</b>	<b>1,820,700.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	102,550,728.00	3,567,556.00	8,780,196.99	114,898,480.99
<b>C02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>102,550,728.00</b>	<b>3,567,556.00</b>	<b>8,780,196.99</b>	<b>114,898,480.99</b>
<b>C04</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
<b>C05</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
<b>C06</b>	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
<b>C07</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
<b>C08</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>102,550,728.00</b>	<b>3,567,556.00</b>	<b>8,780,196.99</b>	<b>114,898,480.99</b>
<b>D01</b>	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>102,550,728.00</b>	<b>3,567,556.00</b>	<b>8,780,196.99</b>	<b>114,898,480.99</b>
<b>D02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>102,550,728.00</b>	<b>3,567,556.00</b>	<b>8,780,196.99</b>	<b>114,898,480.99</b>
<b>D04</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
<b>D05</b>	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
<b>D06</b>	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
<b>D07</b>	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
<b>D08</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	(45,205,775.93)	(45,205,775.93)
<b>D09</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>102,550,728.00</b>	<b>3,567,556.00</b>	<b>(36,425,578.94)</b>	<b>69,692,705.06</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,663,833,700.00</b>	<b>1,552,779,399.47</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,663,833,700.00</b>	<b>1,552,779,399.47</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,413,212,300.00</b>	<b>1,319,228,729.47</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>545,670,200.00</b>	<b>518,293,557.27</b>
210101	Үндсэн цалин	295,969,100.00	298,079,186.79
210102	Нэмэгдэл	170,075,100.00	136,179,834.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,212,000.00	49,644,000.00
210104	Урамшуулал	25,414,000.00	34,390,536.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт</b>	<b>70,458,800.00</b>	<b>65,322,870.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,632,000.00	44,433,015.30
210202	Тэтгэмжийн даатгал	5,456,700.00	5,227,413.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,728,400.00	2,610,406.82
210204	Ажилгүйдлийн даатгал	2,728,400.00	2,610,406.82
210205	Эрүүл мэндийн даатгал	10,913,300.00	10,441,627.37
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>56,778,700.00</b>	<b>54,066,130.00</b>
210401	Бичиг хэрэг	5,600,000.00	4,864,650.00
210402	Тээвэр, шатахуун	36,000,000.00	45,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,178,700.00	4,201,480.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>1,782,900.00</b>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,782,900.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>132,531,000.00</b>	<b>131,987,530.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,931,000.00	41,291,870.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000,000.00	-
210604	Урсгал засвар	85,600,000.00	90,695,660.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>40,238,500.00</b>	<b>35,770,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	40,238,500.00	35,770,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ-ний төлбөр, хураамж</b>	<b>466,752,200.00</b>	<b>414,816,274.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	462,300,000.00	411,974,377.20
210803	Даатгалын үйлчилгээ	4,050,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276,200.00	266,397.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	126,000.00	75,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>99,000,000.00</b>	<b>98,972,368.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,000,000.00	92,972,368.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>250,621,400.00</b>	<b>233,550,670.00</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>175,000,000.00</b>	<b>175,000,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	175,000,000.00	175,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>75,621,400.00</b>	<b>58,550,670.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,213,400.00	21,213,360.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,623,500.00	8,623,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,784,500.00	28,713,810.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,663,833,700.00</b>	<b>1,552,779,399.47</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,663,833,700.00</b>	<b>1,552,779,399.47</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,663,833,700.00	1,552,779,399.47
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>54,755,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>53,895,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	53,895,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,685,500.00
<b>210604</b>	Урсгал засвар	3,685,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,210,000.00
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,210,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,000,000.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000,000.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	860,000.00
<b>213503</b>	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	860,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>54,755,500.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	54,755,500.00
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,070,000.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,685,500.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,890.3 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. ГХУСЗардлаас цагдаагийн газрын хүсэлтээр 10,000.0 мянган төгрөгийн хурд хэмжигч багаж худалдаж авсан боловч хүлээлгэж өгөөгүй, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
2. Элэгдлийн зардлыг санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 6,890.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитаар нийт 80,735.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 1,588.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 79,147.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2, албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

#### 3.1 Төлбөрийн акт:

1. Ажилласан өдөр, ээлжийн амралтын өдрийг давхардуулан тооцож 1,124.5 мянган төгрөг, албан тушаал өөрчлөгдсөн тушаал шийдвэрийн хугацааг үндэслэлгүй 559.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

#### 3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас томилолтоор ажиллаж буй хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож 2,790.0 мянган төгрөг, түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй 4 албан хаагчдад цалингийн нэмэгдэлд 29,007.0 мянган төгрөг, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид 1,745.2 мянган төгрөгийн түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг тус тус илүү олгосон зэрэг нийт 33,542.2 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно.", 2.3-д "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.1-т "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал". 2.2.3. "хоолны зардал" гэсэн заалтыг зөрчсөн;

2. Ашиглалтын гэрээгээр ашиглаж буй аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцны засварын зардалд 15,000.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой тусгаагүй, зураг төсөв гаргаагүй, хуралдааны хоол, цайны завсарлагааны зардлыг хүний тоо, хуралдааны ирцийн бүртгэлийг үндэслэлгүй 30,605.1 мянган төгрөгийг олгосон. Тухайлбал иргэдийн төлөөлөгчдийн хуралдаан, зөвлөл, бүлэг, хороодын хуралд нийт 548 хүн оролцсон боловч хоолны зардлыг 978 хүн, цайны завсарлагаанд 1649 хүнээр тооцсон зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулж нягтлан бодох бүртгэл хөтөлж, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчөн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлэв.
3. Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг илэрхийлээгүй, гүйцэтгэлийг 111.0 сая төгрөгөөр зөрүүтэй, үндсэн хөрөнгийн үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, орон нутгийн санхүүжилтийн 1,663.8 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилт дансаар бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн авлага 0.8 сая төгрөгийг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.1 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн зэрэг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв бэлтгэж ирүүлээгүй тул 2026 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 56 дугаар бүхий хугацаатай албан бичгээр буцаасан боловч 2026 оны 2 дугаар сарын 9-ний өдөр ирүүлж аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудитаар анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчил гаргаж албан үүргээ хангалтгүй биелүүлж байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэснийг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн бүртгэл	1	6,890.0			1	6,890.0						
Хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй зардалд хаасан	1	10,000.0			1	10,000.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>16,890.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>16,890.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Цалин илүү олгосон	1	1,588.4	1	1,588.4									
Төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	45,605.1			1	45,605.1							
Нягтлан бодох бүртгэл	1	0							1		0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>47,193.5</b>	<b>1</b>	<b>1,588.4</b>	<b>1</b>	<b>45,605.1</b>			<b>1</b>		<b>0</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Зөрчилгүй</b>	<b>0</b>	<b>0</b>						
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Хууль тогтоомжийн хэрэгжилт	1	33,542.2			1	33,542.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>33,542.2</b>			<b>1</b>	<b>33,542.2</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 69-А2370449

Чингис хот

ХЭА-2026/145/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 1,031,744.00 /Нэг сая гучин нэгэн мянга долоон зуун дөчин дөрөв/ төгрөгийн цалинг давхардуулан олгосон, албан тушаал өөрчлөгдсөн тушаал шийдвэрийн хугацааг үндэслэлгүйгээр мэргэжилтнээр ажилласан 17 өдрийн цалинг хэлтсийн даргын албан тушаалын цалингаар тооцож 559,600.00 /таван зуун тавин есөн мянга зургаан зуу/ төгрөгийн цалин илүү олгосон зэрэг нийт 1,591,344.00 /Нэг сая таван зуун тавин нэгэн мянга гурван зуун дөчин дөрөв/ төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Илүү олгосон 1,591,344.00 /Нэг сая таван зуун тавин нэгэн мянга гурван зуун дөчин дөрөв/ төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Жавхланд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 210-А2370449

Чингис хот

АЭА-2026/145/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас томилолтоор ажиллаж буй хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож 2,790,000.00 төгрөг,
2. Түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй 4 албан хаагчдад цалингийн нэмэгдэлд 29,006,984.00 /хорин есөн сая зургаан мянга есөн зуун наян дөрөв/ төгрөг,
3. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид 1,745,228.00 /нэг сая долоон зуун дөчин таван мянган хоёр зуун хорин найм/ төгрөгийн түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг тус тус илүү олгосон зэрэг нийт 33,542,212.00 /гучин гурван сая таван зуун дөчин хоёр мянга хоёр зуун арван хоёр/ төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид **цалингийн зөрүүг** олгоно.", 2.3-д "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн **албан тушаалын цалинг** түүнд олгоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.1-т "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал". 2.2.3. "хоолны зардал" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчин төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Жавхлан, нягтлан бодогч Э.Загдхүү нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 211-А2370449

Чингис хот

ХЭА-2026/145/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ашиглалтын гэрээгээр ашиглаж буй аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцны засварын зардалд 15,000,000.00 /арван таван сая/ төгрөгийг зарцуулсан боловч ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой тусгаагүй, зураг төсөв гаргаагүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй,
2. Хуралдааны хоол, цайны завсарлагааны зардлыг хүний тоо, хуралдааны ирцийн бүртгэлийг үндэслээгүй 30,605,100.00 /гучин сая зургаан зуун таван мянга нэг зуу/ төгрөгийг олгосон. Тухайлбал иргэдийн төлөөлөгчдийн хуралдаан, зөвлөл, бүлэг, хороодын хуралд нийт 548 хүн оролцсон боловч хоолны зардлыг 978 хүн, цайны завсарлагаанд 1649 хүний зардал гаргасан зэрэг нийт 45,605,100.00 /дөчин таван сая зургаан зуун таван мянга нэг зуу/ төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулж нягтлан бодох бүртгэл хөтөлсөн, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Анхан шатны баримтыг үндэслэлгүйгээр төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Жавхлан, нягтлан бодогч Э.Загдхүү нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25

Дугаар 225 - А2370449

Чингис хот

ХЭА - 2026/145/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг илэрхийлээгүй, гүйцэтгэлийг 111.0 сая төгрөгөөр зөрүүтэй, үндсэн хөрөнгийн үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, орон нутгийн санхүүжилтийн 1,663.8 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилт дансаар бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн авлага 0.8 сая төгрөгийг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.1 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн зэрэг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв бэлтгэж ирүүлээгүй тул 2026 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 56 дугаар бүхий хугацаатай албан бичгээр буцаасан боловч 2026 оны 2 дугаар сарын 9-ний өдөр ирүүлж аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудитаар анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчил гаргаж албан үүргээ хангалтгүй биелүүлж байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодогч Э.Загдхүүд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг нарийн бичгийн дарга Ш.Жавхлан-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

